



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулж, ахмад настны
хөгжил, оролцоог дэмжих тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь заалтыг тус тус үндэслэн, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн ТУШААХ нь:

1. Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн “Хөрөнгө зарцуулах тухай” А/18 дугаар тушаалын 1 дэх хэсэг, мөн хавсралтад дурьдсан 8820 /найман мянга найман зуун хорин/ ам доллар гэснийг 4620 /дөрвөн мянга зургаан зуун хорин/ ам доллар гэж өөрчилсүгэй.

2. Ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх ажиллагааны хүрээнд Улсын Дээд шүүхийн ахмадын зөвлөлийн гишүүдэд зориулан 2019 оны 07 дугаар сарын 19-нөөс 24-ний өдрүүдэд ОХУ-ын Улан-Үдэ хотод аялал, биеийн тамир спортын арга хэмжээ зохион байгуулахыг Захиргаа удирдлагын хэлтэс /Д.Отгонбаатар/-т даалгасугай.

3. Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 11 070 000 /арван нэгэн сая далан мянган/ төгрөгийг Тамгын газрын даргын 2019 оны “Хөрөнгө зарцуулах тухай” А/18 дугаар тушаалд өөрчлөлт оруулсан дүнгийн зөрүүгээр санхүүжүүлж, зарцуулахыг Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Н.Булгамаад зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.НАРАНПҮРЭВ

050109